

**ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ҮЕИЙН ЖЕНДЭРТ  
СУУРИЛСАН  
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ  
ТЭМЦЭХ НЬ**

**ГАРЫН АВЛАГА**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ҮЕИЙН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН  
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ**

**ГАРЫН АВЛАГА**

## ГАРЧИГ

<b>ГАРЫН АВЛАГЫН ҮНДСЭН ЗОРИЛГО</b> . . . . .	<b>3</b>
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ (ЖСХ)</b> . . . . .	<b>3</b>
Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн төрлүүд . . . . .	3
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ</b> . . . . .	<b>4</b>
ЖСХ-ийн хамрах хүрээ. . . . .	4
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ТЭЙ ТЭМЦЭХЭД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ</b> . . . . .	<b>5</b>
<b>САЛБАР ХООРОНДЫН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА</b> . . . . .	<b>7</b>
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХОД ОРОЛЦОХ ГОЛ ТАЛУУД</b> . . . . .	<b>8</b>
Орон нутгийн байгууллагууд онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авахад тэдний манлайллыг бэхжүүлэх болон чадавхийг дээшлүүлэх. . . . .	8
<b>ЖСХ-ИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ</b> . . . . .	<b>9</b>
ЖСХ-ийн үнэлгээ . . . . .	9
Үнэлгээний үе шат . . . . .	10
Мэдээлэл цуглуулахад баримтлах аюулгүй, ёс зүйтэй аргачлал . . . . .	12
ДЭМБ-ын зөвлөмж . . . . .	12
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ</b> . . . . .	<b>13</b>
Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эрсдэлийг тодорхойлох . . . . .	14
Онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх стратеги . . . . .	15
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ</b> . . . . .	<b>17</b>
ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авахад баримтлах зарчим, стратеги . . . . .	17
ЖСХ-ийн хариу арга хэмжээний пирамид . . . . .	18
Эрүүл мэндийн салбарын оролцоо . . . . .	20
<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИЦУУЛАХ МЕХАНИЗМ</b> . . . . .	<b>22</b>

**ГАРЫН АВЛАГЫН ҮНДСЭН ЗОРИЛГО**

- ▶ Онцгой байдлын үеийн жендэрт суурилсан хүчирхийллээс (ЖСХ) урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх
- ▶ Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар мэдлэг, мэдээлэл олгон, онцгой байдлын үед ажиллах чадавхитай ажилтнуудын тоог нэмэгдүүлэх

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ**

Онцгой байдлын үед жендэрийн тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, эрх мэдэл, хүчний ялгаа ихэсдэг тул хохирогч тусламж авахад улам хүндрэлтэй болж ЖСХ-ийн эрсдэл нэмэгддэг. Тиймээс онцгой байдлын үед ч хүчирхийллийн хохирогчийн амийг аврах болон бусад нэн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж, мөн тухайн үеийн болон ирээдүйд учирч болох эрсдэлүүдийг бууруулах замаар онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай.

**Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн төрлүүд**

1. **Хэвийн амьдралын үед тохиолддог ЖСХ-ийн төрлүүд** нь онцгой байдлын үед ч үргэлжилж, бүр нэмэгдэж болно. Тухайлбал: гэр бүлийн хүчирхийлэл, хүчин, бэлгийн мөлжлөг, аюултай ёс заншил, уламжлал (жишээ нь: эрт гэрлүүлэх)

*Онцгой байдлын үеийн нэмэлт эрсдэл:* стресс, ядуурал, эд хөрөнгөө алдах, гэр бүлийнхнээсээ салах, нийгмийн болон албан ёсны хамгааллын механизм алдагдах, нүүлгэн шилжүүлэх үед гадны туслалцаанаас хамааралтай болох

2. **Онцгой байдлын улмаас тохиолдож буй ЖСХ-ийн төрлүүд.** Тухайлбал:

- ▶ Хууль журам, нийгмийн хэм хэмжээ алдагдсаны улмаас зэвсэгт бүлэглэлийнхний үйлддэг бэлгийн хүчирхийлэл
- ▶ Хүмүүсийг айлган сүрдүүлэх, нүүлгэн шилжүүлэх зорилгоор зэвсэгт бүлэглэлийнхний үйлддэг бэлгийн хүчирхийлэл
- ▶ Хүний хулгай ба бэлгийн боолчлол
- ▶ Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах.

*Онцгой байдлын үеийн нэмэлт эрсдэл:* хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн хамаарал, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, орлогын хомсдол, гэр бүлээсээ салах, нүүлгэн шилжүүлэлт ба нүүлгэн шилжүүлэлтээс буцан ирэх

3. **Бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл.** Энэ нь эрх мэдэл бүхий хүмүүс хямрал, онцгой байдлын үед тусламж үзүүлснийхээ хариуд буюу эрх мэдлийн давуу байдлаа ашиглан бэлгийн харьцаанд орохыг шаарддаг тохиолдлыг хэлнэ. Жишээ нь:

- ▶ Хуарангийн удирдагч өрх толгойлсон эмэгтэйчүүдийг бэлгийн харьцаанд орохыг шаардах

- ▶ Тусламжийн ажилтан хуваарьтай хүнсийг тарааж өгсний хариуд бэлгийн харьцаанд орохыг шаардах
- ▶ Хамгаалалтын ажилтан аюулгүй нэвтрүүлснийхээ хариуд бэлгийн харьцаанд орохыг шаардах гэх мэт.

*Онцгой байдлын үеийн нэмэлт эрсдэл:* нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааны хомсдол, орлогын алдагдал, тусламжаас хараат байдал, ялгаварлан гадуурхсан нийгмийн хэм хэмжээ, жендэрийн тэгш бус байдал.


## ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Онцгой байдлын үеийн ЖСХ-тэй тэмцэхийн тулд үндсэн 2 чиглэлээр анхаарч ажиллана. Эдгээр нь урьдчилан сэргийлэх буюу гамшигт өртсөн хүн ам, ялангуяа охид эмэгтэйчүүдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, эрхийг хангах, мөн хариу арга хэмжээ буюу хүчирхийлэлд өртсөн хүмүүст шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, тэдний эрхийг хүндэтгэх юм.

Мөн онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг төлөвлөх, авч хэрэгжүүлэхдээ ЖСХ-ийн хамрах хүрээг авч үзэж, ЖСХ гэж юу болох, түүний суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүдийг ойлгож мэдэх ёстой.

### ЖСХ-ийн хамрах хүрээ

ЖСХ нь хувь хүн/харилцаа, олон нийт/нийгмийн бүлгүүд, нийгмийн зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг нарийн, түвэгтэй асуудал юм.



**Хувь хүн/харилцааны хүрээнд** тухайн хувь хүний зан авир, амьдралын түүх, харилцаанаас гадна тухайн хүн ЖСХ-ийн хохирогч эсвэл хүчирхийлэгч эсэх, энэ нь тэдэнд хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох хүчин зүйлүүдийг хамтад нь авч үздэг.

**Нөлөөлөх хүчин зүйлс:** Нас, боловсрол, орлогын байдал, мансууруулах бодисын хэрэглээ, хүчирхийллийн түүх, сэтгэлзүйн асуудал, жендэрийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага.

**Эрсдэлт хүчин зүйлс:** Амьдралын үндсэн хэрэгцээ хангагдаагүй байх, өрхийн нөөцийг хүйсээр ялгаварлан тэгш бус хувиарлах, ялгаварлан гадуурхах хандлага бүхий тэгш бус байдал газар авсан байх.

Энэ хүрээнд ЖСХ-ийн хохирогчийн эрхийг хангаж, шаардлагатай тусламжийг үзүүлэх, мөн шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, эргэн хэвийн байдалд ороход нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

**Олон нийт/нийгмийн бүлгүүдийн хүрээнд** тухайн хүний ажиллаж амьдардаг албан болон албан бус нийгмийн хүрээлэл болон энэ хүрээлэл дэх хүмүүс хоорондын харилцааг авч үздэг. Жишээ нь: сургууль, эрүүл мэндийн байгууллага, цагдаа, үе тэнгийн бүлгүүд, тухайн ажилладаг албан байгууллага дахь харилцаа гэх мэт.

**Эрсдэлт хүчин зүйлс:** Олон нийтийн хамгааллын механизм муу, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан аюулгүй байр, орон зай хангалттай биш байх.

Энэ хүрээнд хууль шүүх, аюулгүй байдал, эрүүл мэнд, халамжийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх, мөн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах олон нийтэд түшиглэсэн механизмүүдийг сайжруулах хэрэгтэй.

**Нийгмийн хүрээнд** хүчирхийллийг дэмждэг эсвэл огт дэмждэггүй аль аль соёлыг бий болгоход нөлөөлдөг хүчин зүйлсийг авч үздэг.

**Нөлөөлөх хүчин зүйлс:** Эдийн засаг, нийгмийн бодлогууд, жендэрийн талаарх нийгэм соёлын хэм хэмжээ, хууль эрх зүй, улс төрийн орчин.

**Эрсдэлт хүчин зүйлс:** Эр хүн байх талаар хэвшмэл хортой ойлголтууд, тэдний хүчирхийллийн зан байдлыг өөгшүүлэн дэмжих хандлага, хүчирхийлэл үйлдэгсэд ял шийтгэлгүй өнгөрдөг хууль эрх зүйн хангалтгүй орчин (жишээ нь: ЖСХ-ийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх).

Энэ хүрээнд олон улсын болон үндэсний холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх замаар илүү өргөн хүрээнд хохирогчийн эрхийг таниулах, хамгаалах хэрэгтэй.

---

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ТЭЙ ТЭМЦЭХЭД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ

---

Онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авахдаа а) эрхэд суурилсан, б) олон нийтийг чадавжуулах, в) хохирогч төвтэй гэсэн арга зүйг баримтална.

**Эрхэд суурилсан арга зүй** нь хүн бүр нас, хүйс, гарал үүсэл, нийгмийн байдлаасаа үл хамааран эрх чөлөөтэй, үнэ цэнэтэй, хүчирхийллээс ангид амьдрах эрхтэй гэсэн зарчим дээр тулгуурлах бөгөөд эдгээр эрхийг хангахын тулд ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлын суурь шалтгаануудыг авч үздэг.

Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд, хүүхдүүд, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг онцгой

байдлын үед ч хамгаалах ёстой гэсэн зарчимд суурилдаг.

**Олон нийтийг чадавхжуулах арга зүй** нь нийгэм, жендэрийн харилцааг өөрчлөх, цаашилбал ЖСХ-ийг таслан зогсооход шаардлагатай мэдлэг, ойлголт, нөөц, ур чадварыг олгох замаар хувь хүн, бүлэг, олон нийтийг чадавхжуулахыг зорьдог. Мөн онцгой байдлын үеийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийг боловсруулах бүх шатанд талуудын идэвхитэй оролцоог хангах ёстой гэж үздэг.

Энэхүү арга зүйн гол зорилго нь өөрчлөлт, шударга ёсыг нийгэмд богино болон урт хугацаанд төлөвшүүлэхэд оршино. Ингэхийн тулд ЖСХ-тэй тэмцэх олон нийтийн хэрэгцээ шаардлага, боломж, эрх, үүрэг зэргийг тодорхойлох, ЖСХ-ийн эсрэг арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх ажилд олон нийтийн оролцоо, идэвхи санаачлагыг дэмжих, үйл ажиллагааны өгөөж, үр нөлөөг оролцооны аргаар үнэлэх зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй.

**Хохирогч төвтэй арга зүй** нь хүчирхийллийн хохирогчдийг үйл ажиллагааныхаа гол цөмд тавих замаар чадавхжуулахыг зорьдог арга зүй юм. Мөн хохирогчдын амссан хүчирхийллийн нөхцөл байдалд нөлөөлсөн хувь хүний, нийгэм соёлын хүчин зүйлүүд болон шаардлагатай тусламжийн төрөл, давтамж түүнчлэн тэдний бие махбод, сэтгэл хөдлөл, сэтгэл зүй, оюун санааны байдал болон нийгэм, соёлын нөхцөлийг нь авч үздэг. Энэхүү арга зүй нь:

- ▶ Хүн бүр өөрийн гэсэн онцлогтой;
- ▶ Хүн бүр ЖСХ-д янз бүрийн хариу үйлдэл үзүүлдэг учраас тэдний хэрэгцээ өөр өөр байдаг;
- ▶ Хүн бүр өөрийн гэсэн давуу тал, нөөц боломж мөн даван туулах арга, чадвартай байдаг;
- ▶ Хүн бүр тэдэнд тохиолдсон хүчирхийллийн талаар хэн мэдэх хэрэгтэй, цаашид яах ёстой талаараа өөрөө шийдвэр гаргах эрхтэй гэж үздэг.

Мөн хохирогч бүрийн нөхцөл байдалд тохирсон холбогдох мэдээлэл, тусламж, үйлчилгээгээр хангахын тулд ЖСХ-ийн хариу арга хэмжээ нь тэдний хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд энэхүү хохирогч төвтэй арга зүйн үндсэн зарчимууд нь:

- ▶ Аюулгүй байх
- ▶ Нууцлалыг хамгаалах
- ▶ Ялгаварлан гадуурхахгүй байх
- ▶ Хүндэтгэх, өөрийгөө тодорхойлох боломж өгөх
- ▶ Ямар нэгэн хохирол учруулахгүй байх юм.

## САЛБАР ХООРОНДЫН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### Салбар хоорондын хамтын ажиллагааны загвар



**Хариу арга хэмжээ.** ЖСХ-ийн дараах хортой үр дагаврыг багасгах, цаашид гарч болзошгүй бие махбод, сэтгэл санааны гэмтэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, хохирогчийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн ЖСХ-д хариу арга хэмжээ авах, зан соёлын мэдрэмжтэй, олон салбарын цогц үйлчилгээ үзүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа маш чухал.

**Салбар хоорондын хамтын ажиллагааны загвар.** ЖСХ-ийн эсрэг зохих хариу арга хэмжээг байгууллага эсвэл аль нэг салбар дангаараа цаг алдалгүй авах боломжгүй бөгөөд ЖСХ-ийн хариу арга хэмжээ нь холбогдох байгууллага, хүмүүсийн оролцоог дэмжсэн цогц, салбар болон байгууллага хоорондын нарийн зохион байгуулалттай хамтын ажиллагаа байх ёстой.

**Хүртээмж.** ЖСХ-ийн хохирогчдод шаардлагатай үйлчилгээний хүртээмжид дараах зүйлсийг анахаарч үздэг.

- ▶ Газар зүйн байрлал болон аюулгүй байдал
- ▶ Ажлын цагийн хуваарь нь тохиромжтой эсэх
- ▶ Хувь хүний нууцыг хадгалдаг эсэх
- ▶ Эмэгтэй ажиллагсадтай эсэх
- ▶ Нас, жендэрийн мэдрэмжтэй эсэх
- ▶ Хэлний бэрхшээлийг шийдсэн эсэх
- ▶ Үнийн хувьд боломжийн эсэх

**Холбон зуучлах тогтолцоо.** Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдийг багтаасан, шаардлагатай үед хохирогчийг тухайн үйлчилгээ үзүүлэгчтэй холбож, цаг алдалгүй хэрэгцээт үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн цогц тогтолцоо маш чухал бөгөөд энэ нь ЖСХ-ийн хохирогчдын олон талын хэрэгцээнд нь нийцсэн, шаардлагатай тусламж үйлчилгээг цаг тухайд нь авах боломжоор хангах үндсэн зорилготой.



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХОД ОРОЛЦОХ ГОЛ ТАЛУУД

**Олон улсын байгууллагууд.** НҮБ-ийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчид болон дипломат байгууллагууд, олон улсын иргэний нийгмийн болон ТББ-ууд гэх мэт.

**Засгийн газар.** Засгийн газар, Онцгой Байдлын Ерөнхий Газар, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, цагдаа, эмнэлэг гэх мэт.

**Иргэний нийгмийн байгууллагууд.** Буяны байгууллага, ТББ, олон нийтийн бүлгүүд, эмэгтэйчүүд/залуучуудын байгууллагууд, үйлдвэрчний эвлэл гэх мэт хохирогчдод шууд тусламж үзүүлдэг, хүний эрх болон бодлогын талаар нөлөөллийн ажил хийдэг байгууллагууд.

**Олон нийт.** Ойролцоо гудамж, хороолол, хотхон зэрэг бие биетэйгээ байршилын хувьд ойр амьдарч буй бүлэг хүмүүс (Олон нийтийг татан оролцуулах нь хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг идэвхгүй хүлээн авагч биш, харин шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцад гол үүрэг гүйцэтгэгчид болгодог).

### Орон нутгийн байгууллагууд онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авахад тэдний манлайллыг бэхжүүлэх болон чадавхийг дээшлүүлэх

Тухайн орон нутгийн холбогдох талуудыг онцгой байдлын үеийн ЖСХ-тэй тэмцэхэд шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх зэрэг үйл ажиллагаанд оролцуулж, чадавхийг нэмэгдүүлснээр ЖСХ-тэй тэмцэх үйл ажиллагаа нь илүү тогтвортой, эрхэд суурилсан, хохирогч төвтэй болж, олон нийтийг чадавхжуулж/хөгжүүлдэг.

Ямар ч үед, ялангуяа онцгой байдлын үеийн ЖСХ-тэй тэмцэх аливаа хүчин чармайлт нь хүчирхийлэлд өртсөн хувь хүн төдийгүй олон нийтийн төлөө ажилладаг байгууллагуудын давуу тал, тэсвэр тэвчээр, даван туулах механизмыг улам бүр бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Орон нутгийн манлайллыг бэхжүүлэх, ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх стратегид дараах зүйлс орно:

- ▶ Орон нутгийн санаачлага, бүтцийг бий болгох, дэмжих
- ▶ Орон нутгийн холбогдох талуудтай сайн түншлэлийг бий болгох
- ▶ Асуудлыг үнэлэх, дүн шинжилгээ хийх, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэг үйл ажиллагааны бүхий л үед шатанд орон нутгийн холбогдох талуудын оролцоог хангах
- ▶ Орон нутгийн холбогдох талуудтай хамтран стратегийн төлөвлөлт хийх
- ▶ Орон нутгийн тулгамдсан асуудлаарх яриа хэлэлцээнд залуучуудыг оролцуулах
- ▶ Сургалт явуулах, чадавхийг бэхжүүлэх

## ЖСХ-ИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

### Хүмүүнлэгийн хөтөлбөрийн цикл/шат дараалал



### ЖСХ-ийн үнэлгээ

Хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг ялангуяа охид эмэгтэйчүүдийг ЖСХ-ийн эрсдэлийн үнэлгээнд оролцуулснаар тэд урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд оролцох чадавх нь нэмэгдэж, мөн асуудлыг бие дааж шийдвэрлэх, шаардлагатай арга хэмжээ авах чадвар нь дээшилдэг.

Мөн үнэлгээ нь онцгой байдлын үед авах арга хэмжээг төлөвлөх ажлын нэг чухал хэсэг юм. Эдгээр нь ЖСХ-тэй холбоотой эрсдэл, аюул заналхийлэл, эмзэг байдал, чадавхийн талаар мэдээлэл цуглуулах үр дүнтэй арга хэрэгсэл бөгөөд хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлж, болзошгүй аюул заналхийллийг бууруулахад тусалдаг.

### Үнэлгээний үе шат

1. Зорилгоо тодорхойлох
2. Бэлэн байгаа мэдээллийг тодорхойлох, ашиглах
3. Шаардлагатай мэдээллийг тодорхойлох
4. Үнэлгээг төлөвлөх
5. Мэдээллийг цуглуулах
6. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах
7. Үнэлгээний үр дүн, зөвлөмжийг ойлгомжтой хэлбэрээр холбогдох талуудтай хуваалцах.

#### 1. Үнэлгээний зорилгыг тодорхойлох.

Үнэлгээний гол зорилго нь ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээг үр

дүнтэй төлөвлөж, шаардлагатай арга хэмжээг авахын тулд хувь хүний болон олон нийтийн түвшин дэх ЖСХ-ийн нөхцөл байдлын талаар холбогдох талуудад хангалттай ойлголт өгөхөд туслах явдал юм. Үүнд:

- ▶ ЖСХ-ийн төрөл болон цар хүрээг судлах
- ▶ ЖСХ-ийн талаарх олон нийтийн үзэл бодлыг ойлгох
- ▶ Одоо байгаа аливаа үйлчилгээ болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний давуу болон сул талыг судлах
- ▶ Олон нийтийн болон хүмүүнлэгийн байгууллагуудын нөөц боломжийг тодорхойлох
- ▶ Үйлчилгээ үзүүлж буй хэлбэрийг судлах зэрэг багтана.

Ингэж дүн шинжилгээ хийснээр олон нийт, холбогдох албан тушаалтны ЖСХ-ийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх боломжийг бий болгон, ЖСХ-ийн эсрэг уялдаа холбоотой, үр дүнтэй хамтран ажиллах багийг бүрдүүлэхэд туслана. Мөн ирээдүйд энэ чиглэлээр харьцуулалт, дүн шинжилгээ хийхдээ суурь мэдээлэл болгож ашиглах боломжтой бөгөөд санхүүжилт босгох, бодлого боловсруулах, хүмүүсийн анхаарлыг энэ асуудалд төвлөрүүлэхэд ухуулга нөлөөллийн хэрэгсэл болгон хэрэглэж болно.

Гэхдээ хэрэгцээг тодорхойлох үнэлгээг дараах зорилгоор хийхгүй:

**Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эсрэг арга хэмжээ авах эсэхийг шийдэх зорилгоор хийхгүй.** ЖСХ нь ямар ч цаг үед гарсаар л байдаг бөгөөд энэ нь амь насанд халтай, ноцтой асуудал болохыг холбогдох албан тушаалтнуудад ойлгуулах шаардлагатай. Тиймээс тэд тодорхой “баримт нотолгоо” байгаа эсэхээс үл хамааран ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээг яаралтай авах ёстой.

**Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн тархалтыг илрүүлэх зорилгоор хийхгүй.** Онцгой байдлын үед ЖСХ-ийн тохиолдолыг мэдээлэхгүй байх эрсдэл улам нэмэгддэг. Иймээс тархалтын мэдээлэл нь ихэвчлэн бодитой биш, цуглуулахад хэцүү, эрсдэлтэй, бараг боломжгүй төдийгүй хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд тус болдоггүй.

## 2. Бэлэн байгаа мэдээллийг тодорхойлох, ашиглах

Онцгой байдлын үеийн хязгаарлагдмал цаг хугацаанд үр ашигтай ажиллахын тулд бэлэн байгаа мэдээллээ ашиглахаас эхлэх хэрэгтэй. Үүнд:

- ▶ Онцгой байдлын төрөл, нүүлгэн шилжүүлэлтийн хэлбэр, гамшигт өртсөн хүмүүсийн хүн ам зүйн ангилсан мэдээлэл
- ▶ Соёл, уламжлал, жендэрийн хэм хэмжээ, хүүхдээ асран халамжлах, өсгөн хүмүүжүүлэх хандлага, боловсрол
- ▶ Аюулгүй байдал, түүний дотор хүний эрхийн зөрчил
- ▶ Хууль эрх зүйн орчин (одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогууд, хэрэгжилтийн үнэлгээ)

- ▶ ЖСХ/гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэл зэргийг багтаасан цагдаа, гэмт хэргийн мэдээлэл
- ▶ Эрүүл мэндийн статистик

### 3. Шаардлагатай мэдээллийг тодорхойлох

ЖСХ-ийн эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд нөхцөл байдлыг цогцоор нь харах шаардлагатай. Үүнд:

- ▶ ЖСХ-ийн төрөл ба тархалт
- ▶ Одоо байгаа үйлчилгээнүүд болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээний давуу болон сул талууд
- ▶ Хөрөнгө, нөөц бололцоог бэхжүүлэх хэрэгцээ шаардлага
- ▶ Үйлчилгээний шилдэг аргууд болон үйлчилгээний цэгүүдийн талаарх мэдээлэл
- ▶ Олон нийтийн нийтлэг хандлага, дадал зуршил, ялангуяа ЖСХ-д хандах хандлага

### 4. Үнэлгээг төлөвлөх

Үнэлгээг төлөвлөхдөө, онцгой байдлын үе шат, үнэлгээнд ашиглаж болох эх үүсвэрүүд (хүний нөөц, техник, логистик, санхүү), тухайн орон нутгийн иргэдтэй холбогдох арга замууд, боломж, орон нутагт байгаа үйлчилгээний хүртээмж, цар хүрээ зэргийг анхаарах хэрэгтэй. Мөн гол оролцогч талууд болон үнэлгээний баг доторх мэргэжлийн боловсон хүчнийг тодорхойлож, үнэлгээний багийг цомхон, үр дүнтэй байлгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

### 5. Мэдээллийг цуглуулах

**Дараах мэдээллийг цуглуулна:**

- ▶ ЖСХ-ийн зонхилох төрөл болон тархалт
- ▶ Аюулгүй байдлын эрсдэлүүд
- ▶ Үйлчилгээний хүртээмж, чанар, хамрах хүрээ
- ▶ Хууль эрх зүйн орчин
- ▶ Холбогдох талуудын /үйлчилгээ үзүүлэгчдийн/ хандлага, дадал, баримтлах бодлого
- ▶ Олон нийтийн хандлага, дадал, хэм хэмжээ

**Хэрхэн цуглуулах вэ?**

- ▶ Холбогдох материалуудыг судлах
- ▶ Бүлгийн ярилцлагууд
- ▶ Ярилцлага
- ▶ Аюулгүй ажиллагааны аудит
- ▶ Үйлчилгээний зураглал
- ▶ Зохион байгуулалттай судалгаа
- ▶ Оролцоонд суурилсан үнэлэх аргууд

### **Мэдээлэл цуглуулахад баримтлах аюулгүй, ёс зүйтэй аргачлал**

ЖСХ-тэй холбоотой асуудлууд нь маш эмзэг асуудлууд байдаг. Энэ мэдээллийг цуглуулах болон бусдад түгээх нь судалгаанд оролцогч, олон нийт, мэдээлэл цуглуулагчдад аюултай, бүр амь насанд нь ч заналхийлж болзошгүй. Тиймээс урьдчилан бодож, төлөвлөх хэрэгтэй ёс зүй, аюулгүй байдлын олон асуудал бий. Мөн үнэлгээний үе шат бүрт (мэдээлэл цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх, бусдад хуваалцах) холбогдох талууд дараах зүйлийг анхааралтай авч үзэх ёстой.

- ▶ Мэдээллийг хэрхэн ашиглах вэ?
- ▶ Мэдээллийг хэн үзэх эрхтэй вэ?
- ▶ Мэдээллийг хэрхэн, хэнд тайлагнах вэ?
- ▶ Үүнийг ямар зорилгоор тайлагнах вэ?
- ▶ Мэдээлэл хэнд, хэзээ ашиг тустай вэ?

Хүний амь настай холбоотой учраас онцгой байдлын үед яаралтай арга хэмжээ авах ёстойг мөн хүн хүч, техникийн нөөц боломж ба хязгаарлагдмал байдлыг анхаарч үзэх хэрэгтэй. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхдээ дараах зүйлсийг анхаарна:

- ▶ ЖСХ нь ихэвчлэн мэдээлэгддэггүй, нуугдмал байдаг.
- ▶ ЖСХ-ийн талаар асуух нь аюултай бөгөөд ёс зүй, аюулгүй байдлын ноцтой асуудал үүсгэж болно.
- ▶ Ихэнх газар хохирогчийг буруутгадаг.
- ▶ Арга хэмжээ авч туслах хүмүүс нь асуудалд яг яаж хандаж, юу хийхээ мэддэггүй.

### **Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын зөвлөмж**

*(ДЭМБ-ын Онцгой байдлын үед бэлгийн хүчирхийллийг судлах, баримтжуулах, хянах Ёс Зүй, Аюулгүй Ажиллагааны Зөвлөмжөөс иш татсан болно.)*

**Эрсдэл ба ашиг тус.** Бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулахад оролцож буй хүмүүс болон олон нийтэд ирэх үр өгөөж нь тэдэнд учирч болзошгүй эрсдлээс илүү байх.

**Арга зүй.** Мэдээлэл цуглуулах, баримтжуулах ажлыг судалгаанд хамрагдаж буй хүмүүст хамгийн бага эрсдэлтэй, зөв арга зүй, орчин үеийн сайн туршлага дээр тулгуурласан аргаар хийх.

**Шаардлагатай үйлчилгээнд нь зуучлах.** Хохирогчоос бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийг авахыг өмнө шаардлагатай тохиолдолд тэдэнд үзүүлэх анхан шатны тусламж, дэмжлэгийг орон нутгийн түвшинд үзүүлэх боломжтой байх.

**Аюулгүй байдал.** Бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулахад оролцсон бүх хүмүүсийн аюулгүй байдал нэн чухал бөгөөд ялангуяа онцгой байдлын үед үүнийг байнга анхаарч, хяналт тавьж байх.

**Нууцлал.** Бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгсөн хүмүүсийн нууцлалыг хангаж, тэднийг хамгаалах.

**Зөвшөөрөл авах.** Бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх боломжтой хүн бүрээс мэдээлэл цуглуулах аливаа үйл ажиллагаанд оролцохоос нь өмнө зөвшөөрөл /сайтар тунгаан бодсоны үндсэн дээр сайн дураараа, ямар нэгэн шахалтгүйгээр өгсөн зөвшөөрөл/ авах.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь ЖСХ-ийн суурь шалтгааныг арилгах болон онцгой байдлын улмаас үүсч болзошгүй нэмэлт эрсдэлийг бууруулахад чиглэдэг. Эдгээр нэмэлт эрсдэлүүд нь:

- ▶ Иргэдийг олноор нь шилжүүлэн байршуулах
- ▶ Нэн шаардлагатай үйлчилгээ хангалтгүй байх
- ▶ Хууль эрх зүйн хамгаалалтын үр дүнтэй механизм байхгүй эсвэл хангалтгүй байх
- ▶ Гэр бүлээсээ холдох, салах
- ▶ Эд хөрөнгө, эсвэл орлого алдагдах гэх мэт.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үйл ажиллагааны түвшин бүрт, онцгой байдлын үе шат бүрт тохиромжтой цогц байх шаардлагатай. Үүний тулд нийгэм дэх хүйсээр ялгаварлан гадуурхах хандлага, үйлдэл болон ЖСХ-д өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг тухайн орчны хүчин зүйлсийг тусгайлан анхаарах хэрэгтэй. Мөн хувь хүн, олон нийтийн болон нийгмийн түвшинд авах арга хэмжээг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

### Анхан шатны арга хэмжээ

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхийн тулд хандлага зан үйлийг өөрчлөхөд анхаарч, нийгмийн янз бүрийн түвшинд ажиллаж, ЖСХ-ийн суурь шалтгаан болсон ялгаварлан гадуурхах хандлага, хэм хэмжээ, зан үйлийг өөрчлөхөд анхааран ажиллах хэрэгтэй.

Жишээ нь:

- ▶ ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх сургуульд түшиглэсэн арга хэмжээнүүд
- ▶ Жендэрийн тэгш бус байдал, ЖСХ-ийн талаар мэдлэг ойлголт өгөх мессэжүүд
- ▶ Жендэрийн тэгш бус байдлыг дэвэргэсэн сөрөг хандлагуудыг таслан зогсоох үе тэнгийнхний сүлжээ
- ▶ Эрчүүдийн зан үйлийг өөрчлөхөд тусгайлан чиглэсэн кампанит ажлууд

### Хоёр дахь шатны арга хэмжээ

Онцгой байдлын нөхцөлд, тодорхой бүлгийн хүмүүст ЖСХ-ийн үзүүлэх шууд нөлөөллийг багасгах. Үүнд бэлэн байдлыг хангах, шат дараатай хариу арга хэмжээ орно.

Жишээ нь:

- ▶ ХДХВ, БЗДХ-ын болзошгүй эрсдлийн дараах урьдчилан сэргийлэх болон яаралтай хамгаалах эмээр хангах
- ▶ Жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслээр хангах
- ▶ Түр хамгаалах байр байгуулах
- ▶ ЖСХ-ийн эрсдлийг бууруулах, илрүүлэх, хариу арга хэмжээ үзүүлэх талаар хамтарсан багийн гишүүдийг сургах

### Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эрсдлийг тодорхойлох

ЖСХ-ийн төрөл тус бүр хувь хүн, олон нийт, нийгмийн түвшинд нөлөөлөх өөр өөрийн гэсэн онцлогтой эрсдэлт хүчин зүйлүүд байдаг. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааны хүрээнд авах арга хэмжээг боловсруулахдаа тухайн онцгой байдлын нөхцөлд ямар төрлийн ЖСХ гарч байгааг болон түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох ёстой. Үүний тулд онцгой байдлын улмаас ЖСХ гарч байгаа эсэх, тийм бол уг хүчирхийлэл хэрхэн, яагаад гарч байгааг тодорхойлох мөн онцгой байдал үүсэхээс өмнө тухайн төрлийн ЖСХ гарч байсан эсэх, тийм бол уг хүчирхийлэл гамшгийн үед хэрхэн, яагаад даамжрах магадлалтай вэ гэдгийг тодорхойлох нь чухал.

Мөн ЖСХ-ийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхдөө дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй:

- ▶ ЮУ БОЛСОН БЭ? Ямар асуудал тулгарсан болон онцлон юуг анхаарах шаардлагатай вэ? ЖСХ-ийн ямар эрсдэлүүд байна вэ? Ямар төрлийн хүчирхийлэл яагаад гарч байна вэ? Охид эмэгтэйчүүдийн хувьд яаралтай шийдвэрлэх ямар хэрэгцээ байна вэ?
- ▶ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЯМАР ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙХ ВЭ?
- ▶ АСУУДЛЫГ ШИЙДЭХ ЗОРИЛГООР ХЭН, ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?
- ▶ ЭДГЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР БИД ЮУ ХИЙЖ БОЛОХ, МӨН ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ? Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх бидний чадавх хэр түвшинд байна вэ? Бидэнд хэр зэрэг нөөц байгаа вэ?

Онцгой байдлын үеийн ЖСХ-ийн эрсдэл, аюул заналхийллийг нарийвчлан тодорхойлох нь тухайн эрсдэлийг үр дүнтэй бууруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хурдан хугацаанд үр дүнтэй авч хэрэгжүүлэх боломжийг олгодог.

$$\text{ЭРСДЭЛ} = \text{Аюул заналхийлэл} + \text{Эмзэг байдал} \times \text{Цаг хугацаа}$$

Эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах гурван үндсэн зүйлийг анхаарна:

**Хариуцлагыг бий болгож аюулыг бууруулах.** Төр, олон нийт, хувь хүмүүсийг хамгаалах төрийн үүрэг хариуцлагыг идэвхжүүлэх. Үүнд хүчирхийллээс урьдчилан

сэргийлэх, аюул заналхийллийг таслан зогсоох, хохирогчдод тусламж үзүүлэх үйл ажиллагааг хариуцсан талуудыг шууд болон шууд бус байдлаар татан оролцуулах.

**Олон нийтийг оролцуулж эмзэг байдлыг бууруулах.** Хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүн амын бүлэгт өөрсдийгөө хамгаалах арга замыг тодорхойлж, боловсруулахад нь туслах. Үүнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг багтаах.

**Эрсдэлд өртөх магадлалыг бууруулж аюулын хугацааг багасгах.** Ялангуяа эрсдэл нэн өндөртэй үеийг онцгойлон анхаарч, сөрөг үр дагавараас хамгаалах арга хэмжээг авч, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хугацааг багасгах.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СТРАТЕГИ



### Нийгмийн түвшинд онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх нэн шаардлагатай арга хэмжээ:

- ▶ Дагаж мөрдөх дүрэм журмыг сайтар мөрдөхийг таниулах
- ▶ Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын байгууллагуудтай ажиллах
- ▶ Хуулийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
- ▶ Тухайн нөхцөл байдалд тохирсон хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах
- ▶ Олон улсын байгууллагууд, хүчний байгууллагуудыг оролцуулах
- ▶ Хүний эрхийн талаарх сургалт зохион байгуулах
- ▶ Зарим төрлийн аюул заналхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах



### **Гэр бүл, олон нийтийн түвшинд онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх нэн шаардлагатай арга хэмжээ:**

- ▶ Аюулгүй байдлын арга хэмжээг авах
- ▶ Ялгаварлан гадуурхах, жендэрийн болон нийгэмд тогтсон хэм хэмжээг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах
- ▶ Эрсдэл, эмзэг байдлыг бууруулах
- ▶ Нөөц баялаг болон үйлчилгээг хэн хүртэж, хэн хянаж байгааг нягтлах
- ▶ Охид, эмэгтэйчүүдийг дэмжих, чадавхжуулах орчныг бүрдүүлэх
- ▶ Хууль эрхзүй, нийгмийн хамгааллыг дэмжих

### **Бэлгийн мөлжлөг болон хүчирхийлээс урьдчилан сэргийлэх нэн шаардлагатай арга хэмжээ:**

- ▶ Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн эсрэг ёс зүйн дүрэм болон гомдол гаргах, хүлээн авах, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх
- ▶ Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн дуудлага, мэдээлэлд хариу өгөх, улмаар уг асуудлыг шийдвэрлэдэг системийг бий болгох
- ▶ Бодлого, дүрэм журам боловсруулах, хүмүүсийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор уг асуудлыг хариуцсан ажилтан томилох
- ▶ Оролцогч бүх талуудын бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, ялангуяа энэ төрлийн хүчирхийллийн тохиолдлуудыг шийдвэрлэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээ, мөн урьдчилан сэргийлэх чиглэлд тухайн байгууллага, ажилтнуудын гүйцэтгэх үүргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- ▶ Олон нийтэд өөрсдийнх нь эрхийн талаарх ойлголт мэдлэгээ дээшлүүлэхэд нь туслах
- ▶ Амьдралын наад захын хэрэгцээг нь хангах, амьжиргааг нь дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх замаар эмзэг байдлыг нь бууруулах

---

## **ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ**

---

### **ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авахад баримтлах зарчим, стратеги**

#### **1. Аюулгүй байдлыг хангах**

ЖСХ-д өртсөн тухайгаа мэдээлсэн хүмүүс дахин хүчирхийлэгчийн зүгээс болон олон нийтийн зүгээс хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй.

Стратеги:

- ▶ Хүчирхийллийн хохирогчийн нууцыг хадгалж, шаардлагатай тусламж үйлчилгээгээр хангах
- ▶ Хүчирхийллийн хохирогчдод боломжит нөөц, сонголтыг ашиглан аюулгүй байдлын эрсдэлээ тодорхойлж, шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- ▶ Хүүхдүүд, гэр бүлийн гишүүд, хүчирхийллийн хохирогчдод тусалсан хүмүүсийн

аюулгүй байдлыг хангах хэрэгцээг тодорхойлох

- ▶ Нууцлалыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх
- ▶ Мэдээллээр бүрэн хангасны үндсэн дээр шийдвэр гаргах боломжийг олгож, хохирогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэмжээ авахгүй байх

## 2. Нууцлалыг хангах

Мэдээллээр бүрэн хангасны үндсэн дээр хохирогчийн зүгээс мэдээллийг задруулахыг зөвшөөрөөгүй тохиолдолд ямар ч мэдээллийг хэзээ ч, хэнд ч задруулж болохгүй.

Стратеги:

- ▶ Хохирогчтой ярилцахдаа ганцаарчлан ярилцах боломжтой өрөөг ашиглах
- ▶ Зөвхөн хангалттай мэдээлэл авсны дараа хохирогч өөрөө хүссэн тохиолдолд холбогдох мэдээллийг бусадтай хуваалцах
- ▶ Бүхбичиг баримтыг аюулгүй газар хадгалж, гамшиг тохиолдоход баримт бичгүүдийг өөр газар шилжүүлэн хадгалах эсвэл устгах төлөвлөгөөг боловсруулсан байх
- ▶ Нууцлалыг заавал хадгалахгүй байх онцгой тохиолдлууд:
  - ▶ Хүүхэд хүчирхийлэлд өртөж/өртсөн байвал
  - ▶ Хууль тогтоомжийн дагуу мэдээлэх үүрэгтэй үед
  - ▶ Хохирогч өөрийгөө гэмтээх магадлалтай гэж үзсэн тохиолдолд

## 3. Хүндлэл ба шийдвэрийг хохирогчоор өөрөөр нь гаргуулах

Хохирогч цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлох гол хүн нь байна. Мөн өөрсдийг нь эргэн хэвийн байдалд оруулах аливаа үйл ажиллагаанд туслах, уг хүчирхийллээс үүдэлтэй асуудлыг шийдэх боломжийг бүрдүүлэх гол хүн нь байна.

Стратеги

- ▶ Бүх ажилтнууд хохирогчдод хүндэтгэлтэй хандахаас гадна хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах талаар мэдлэгтэй байх
- ▶ Хохирогчидтой ярилцлага, үзлэг хийх эмэгтэй ажилтнуудтай байх
- ▶ Хохирогчидтой ажилладаг хүмүүс зохих мэдлэг, ур чадвартай байх
- ▶ Үйлчилгээ үзүүлэгчид нь бусдыг шүүмжилдэггүй, тухайн нийгэм/соёлын нөхцөл байдалд мэдрэмжэй ханддаг байх
- ▶ Хохирогчийн хүчирхийллийн түүхийг аль болох дахин дахин яриулахгүй байх

## 4. Үл ялгаварлан гадуурхах

Хүн бүр жендэр, нас, хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө, хэл, шашин болоод улс төрийн итгэл үнэмшил, бэлгийн чиг хандлага, нийгмийн анги давхараагаасаа үл хамааран хамгийн сайн тусламж үйлчилгээг авах эрхтэй.

Стратеги:

- ▶ Ажилтнуудынхаа үнэ цэнэ, хандлага, итгэл үнэмшлийг өөрчлөх замаар үл ялгаварлан гадуурхах үзлийг дэмжих

- ▶ Ялгаварлан гадуурхалын эсрэг тодорхой бодлоготой байх
- ▶ Хүний эрх, хүмүүнлэгийн зарчим, холбогдох байгууллагуудын бодлогуудын талаар ажилтнуудаа сургах
- ▶ Үйлчилгээ болон үйлчилгээг хүргэж байгаа арга зам нь тодорхой бүлгүүдийн онцлог хэрэгцээг тусгасан байх (жишээ нь: ЛГБТИ, эрчүүд ба хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон олон төрлийн ялгаварлан гадуурхалтанд өртөх эрсдэлтэй хүмүүс гэх мэт)

### ЖСХ-ийн хариу арга хэмжээний пирамид



### Анхан шатны үйлчилгээ, аюулгүй байдал

Стратеги, үйл ажиллагаа:

- ▶ Аюулгүй хамгаалах байр болон анхан шатны хэрэгцээг хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх
- ▶ Үзүүлж буй бүхий л үйлчилгээ болон хүмүүнлэгийн тусламж хохирогч төвтэй байх
- ▶ Хүмүүнлэгийн тусламж нь аюулын эрсдэлийг нэмэгдүүлдэггүй байх
- ▶ ЖСХ-ийн орчний болон нөхцөл байдлын эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх аюулгүй байдал, хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг хамгаалах, тэдний нэн шаардлагатай хэрэгцээг хангах үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ.

### Гэр бүл, олон нийтийн дэмжлэг

Стратеги, үйл ажиллагаа:

- ▶ Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх
- ▶ Олон нийтийн бие биедээ тусалдаг, уян хатан стратегитай болохыг дэмжих
- ▶ Хохирогч төвтэй эдгээх, ариусгах уламжлалт ёслол, зан үйлийг дэмжих

- ▶ Хохирогч төвтэй, шударга ёсыг сэргээх үйл явцыг дэмжих
- ▶ Боловсрол, амьжиргааг дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжих

Гэр бүлийн болоод ойр орчны хүмүүс нь хохирогчид хүчирхийллээс үүдэлтэй сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлсэн сөрөг нөлөөг багасгах тал дээр дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэнэ.

### **Мэргэшсэн бус, хохирогчид чиглэсэн үйлчилгээ**

Стратеги, үйл ажиллагаа:

- ▶ Зөвхөн тухайн хохирогчид зориулсан үйлчилгээг үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хянах
- ▶ Сэтгэлзүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх
- ▶ Амьжиргааг дэмжих, эргэн нийгэмшүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн бусад арга хэмжээг авах
- ▶ Соёлын онцлогыг харгалзсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх

Хүчирхийллийг даван туулах, эргэн хэвийн байдалд ороход нь хохирогчдод шаардлагатай, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд чиглэнэ.

### **Мэргэшсэн үйлчилгээ**

Стратеги, үйл ажиллагаа:

- ▶ Сэтгэлзүйн болон сэтгэл заслын үнэлгээ, тусламж үйлчилгээ
- ▶ Нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Өмнө дурьдсан тусламж үйлчилгээнээс гадна гүн хямралд орсон цөөн тооны хохирогчдод нэмэлт мэргэшсэн үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ.

### **Эрүүл мэндийн салбарын оролцоо**

Төрөл бүрийн чиглэлээр мэргэшсэн маш олон тооны эрүүл мэндийн ажилтнууд (уламжлалт анагаах ухааны эмч нар бас орно) ажил үүргээ гүйцэтгэж байхдаа ЖСХ-ийн хохирогчтой учирч болно. Иймээс тэд ЖСХ болон ЖСХ-ийн хохирогчдод үзүүлдэг тусламж үйлчилгээний системийн талаар анхан шатны мэдлэгтэй байх ёстой.

ЖСХ бол хохирогчийн бие, сэтгэц, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон тэднийг сайн сайхан амьдрахад нь нөлөөлдөг нийгмийн эрүүл мэндийн асуудал юм. Зарим хохирогчийн хувьд эрүүл мэндийн байгууллага нь тэдний ханддаг цорын ганц албан ёсны тусламж хүсдэг газар юм. Тиймээс эрүүл мэндийн салбар нь үйлчилгээ, дэмжлэг авах хамгийн анхний чухал цэг байдаг.

### Онцгой байдлын үед эрүүл мэндийн ажилчдийн гүйцэтгэх үүрэг:

- ▶ Зөвхөн бэлгийн хүчирхийлэл төдийгүй гэр бүлийн хүчирхийлэл зэрэг бүх төрлийн ЖСХ-ийн хохирогчдыг сайн чанарын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжоор хангах
- ▶ ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, түүнээс гарсан үр дагаваруудыг зохицуулах/шийдвэрлэх
- ▶ Сэтгэлзүйн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, эсвэл холбогдох мэргэжлийн үйлчилгээнд зуучилж өгөх

### ЖСХ-ийн хохирогчдод зориулсан эрүүл мэндийн салбарын авах анхан шатны арга хэмжээнүүд

#### 1. Эмнэлзүйн тусламж

- ▶ Хүчирхийлэл/хэрэг явдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах
- ▶ Нарийвчилсан үзлэг хийж, баримтжуулах
- ▶ Хохирогчийн гэмтлийг эмчлэх
- ▶ БЗДХ-ын эрсдэлийг үнэлж, шаардлагатай тусламж үзүүлэх
- ▶ Жирэмсэн болох эрсдэлийг үнэлж, жирэмслэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- ▶ Сэтгэлзүйн болон бусад зөвлөгөө өгч, туслах
- ▶ Дараа дараагийн уулзалт хийж, явцыг ажиглах, хянах, арга хэмжээг авах

#### 2. Хууль шүүхийн ажиллагаанд зориулж нотлох баримт бүрдүүлэх

- ▶ Хүчирхийллийн түүхийг тэмдэглэж авах
- ▶ Эрүүл мэндийн болон сэтгэлзүйн үзлэг хийх
- ▶ Лабораторийн шинжилгээнүүдийг хийж, гэмтлийг баримтжуулах

*Жич: Тухайн тохиолдол нь хүчингийн хэрэг мөн эсэхийг эрүүл мэндийн салбар тодорхойлохгүй.*

#### 3. Бусад шаардлагатай тусламжид холбон зуучлах

- ▶ ЖСХ-ийг илрүүлэх, хохирогч өөрөө ЖСХ-ийг ил гаргахад дэмжлэг үзүүлэх
- ▶ Цаашид дахин хүчирхийлэлд өртөх эрсдэл гэх мэт өвчтөн/хохирогчийн нөхцөл байдал, хэрэгцээг үнэлэх
- ▶ Хохирогчид зориулсан үйлчилгээ, холбон зуучлах системийн талаарх мэдлэгтэй байж, хохирогчийг зөв сонголт хийхэд нь туслах
- ▶ ЖСХ-ийн хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх

#### Сэтгэлзүйн анхан шатны тусламж

ЖСХ нь биеийн эрүүл мэндээс гадна сэтгэцийн эрүүл мэндэд ихээхэн хор хөнөөлтэй. Зарим хохирогчдод ЖСХ-ээс улбаатай сэтгэлзүйн асуудлуудыг даван туулахад нэмэлт дэмжлэг шаардлагатай байдаг. Үүнд дараах зүйлс орно:

- ▶ Хөндлөнгөөс оролцолгүйгээр аливаа тусламж дэмжлэг үзүүлэх
- ▶ Тулгарч буй асуудал, хэрэгцээг нь үнэлэх
- ▶ Үндсэн хэрэгцээгээ хангахад нь туслах
- ▶ Хөндлөнгөөс нөлөөлөхгүйгээр хохирогчийг сонсох
- ▶ Тайвшрахад нь туслах
- ▶ Мэдээлэл, үйлчилгээ, нийгмийн дэмжлэг авахад нь туслах
- ▶ Дараа дараагийн болзошгүй хор хөнөөлөөс хамгаалах

ЖСХ-ийн сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах хүчин зүйлс:

- ▶ Хүчирхийлэлд хариу үзүүлж байхдаа хяналттай, сонголттой байх
- ▶ Амьдралын наад захын хэрэгцээг хангах материаллаг дэмжлэг, эх үүсвэртэй байх
- ▶ Гэр бүл, найз нөхдийн зүгээс сэтгэлзүйн дэмжлэг авах боломжтой байх

### **Онцгой байдлын үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай анхан шатны багц тусламж үйлчилгээ**

Энэ нь онцгой байдлын үеийн хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны багц юм.

Үүнд дараах зүйлс орно:

- ▶ Бэлгийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах
- ▶ Эх нярайн эндэгдэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
- ▶ БЗДХ/ХДХВ-ийн халдварыг бууруулах
- ▶ Бэлгийн болон нөхөн үржихүйн цогц үйлчилгээний төлөвлөгөө

---

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИЦУУЛАХ МЕХАНИЗМ**

---

Онцгой байдлын үеийн ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход зохицуулах механизм хамгийн чухал юм.

Ямар ч албан тушаалтан эсвэл байгууллага дангаараа ЖСХ-ийн асуудлыг бүрэн шийдвэрлэх эрх, хүчин чадал, нөөц боломж байхгүй. ЖСХ-ийн эсрэг үйл ажиллагаанд оролцож буй талууд бие биенээ нөхөж, дэмжиж ажиллах зохицуулалт хэрэгтэй.



### Ерөнхий зохицуулалт

Ерөнхий зохицуулалт гэдэгт улс орны хэмжээнд эсвэл хямралыг цогцоор нь авч үзсэн үйл ажиллагааг хэлнэ. Үүнд дараах зүйлс орно.

- ▶ Стратегийн төлөвлөлт
- ▶ Мэдээлэл цуглуулах, хяналт тавих, мэдээлэл солилцох, ухуулах ажилд дэмжлэг үзүүлэх
- ▶ Нөөцийг хуваарилах, хариуцлагатай байдлыг хангах
- ▶ Хөдөлмөрийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулах
- ▶ Стандарт, сайн туршлага дээр үндэслэн үр дүнтэй арга хэмжээ авах талаар хэлэлцэх, тэрхүү арга хэмээг тогтвортой байлгах
- ▶ Тогтвортой хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд удирдан зохион байгуулах

### Орон нутгийн түвшин дэх зохицуулалт

Байгууллага болон салбар хоорондын ЖСХ-ийн асуудал хариуцсан холбогдох талуудын хоорондын зохицуулалтыг хэлнэ. Үүнд дараах зүйлс орно:

- ▶ Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлох
- ▶ Үйлчилгээнд холбон зуучлах протокол боловсруулах, хэрэгжүүлэх
- ▶ Үйлчилгээний түвшний болон бусад мэдээллийг цуглуулах, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах
- ▶ Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаануудыг цогцоор нь төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих
- ▶ Хамтарсан ухуулга нөлөөлөл хийх
- ▶ Олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд хамтран оролцох

### Тухайн тохиолдлын зохицуулалт

Аль ч байгууллага, салбар тусламж хүсэж ирсэн хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хохирогч төвтэй цогц үйлчилгээг хүргэх ёстой.

Тухайн тохиолдлын зохицуулалт нь кэйс менежементийн аргаар хийгддэг. Энэ нь хохирогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боломжит нөөц, сонголт, үйлчилгээнүүдийг үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулах, хянах, дахин үнэлэх олон салбарыг хамарсан үйл явц бөгөөд тухайн ЖСХ-ийн хохирогч олон салбараас үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд хамгийн тохиромжтой арга юм.



---

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

---

- ▶ Managing Gender-Based Violence Programmes in Emergencies (UNFPA, 2017)
- ▶ Managing Gender-Based Violence Programmes in Emergencies Phase 2 Training (UNFPA, International Medical Corps, Department of State of the United States of America, Global Protection Cluster, 2017)
- ▶ WHO Ethical and Safety Recommendations for Researching, Documenting and Monitoring Sexual Violence in Emergencies (World Health Organization, 2007)